

Нэг. ХӨМРӨГ ҮҮСГЭГЧ БАЙГУУЛЛАГЫН ТҮҮХ

1978 онд Улаанбаатар хотын АДХ-ын Гүйцэтгэх Захиргааны гишүүд, БНМАУ-ын Сангийн яам, Ардын боловсролын яамны коллегийн хамтарсан хурлын 257/291/325 тоот тогтоолын дагуу Сүхбаатар дүүргийн сургууль цэцэрлэгүүдийн нэгдсэн аж ахуйн төв нэртэйгээр байгуулагдан 1980-аад оны сүүл хүртэл үйл ажиллагаа нь явагдаж иржээ.

1990 Үндсэн хууль өөрчлөгдөж, түүнд нийцсэн “Аж ахуйн нэгж компанийн тухай” шинэ хууль гарснаар нэгдсэн аж ахуйн төвүүд бүтэц, зохион байгуулалтын хувьд өөрчлөгдөж, компанийн зохион байгуулалтаар ажиллах болсон билээ.

Чингэлтэй дүүргийн Сургалт үйлдвэрлэлийн төв нь дүүргийн цэцэрлэгүүдийг хоол хүнсээр хангахаас гадна дүүргийн сургуульд суралцах боломжгүй өрхийн хүүхдүүдийг сурган мэргэжил олгодог байжээ.

Дүүрэг бүрийн дэргэд ажиллаж байсан цэцэрлэг, сургуулиудын нэгдсэн аж ахуйн төвүүд татан буугдаж, дүүрэг бүрийн Засаг даргын захирамжаар тус бүрдээ “Бүрэн бус хариуцлагатай компани”-ууд байгуулагдаж, дүүргийн Засаг даргын захирамжаар компанийн захиралуудыг тус бүрд нь томилсон байна.

1992 оноос Бүгд найрамдах Монгол ард улсын “Аж ахуй нэгжийн тухай “шинэ хуулийн дагуу “Залаат” нэртэй компани болж захирлаар нь Ц.Дангаасүрэн, “Чингэлтэйн үйлдвэр сургалтын төв ” нэртэй компани болж захирлаар нь Лхамаасүрэн томилогдон ажиллаж байжээ.

Улс орон зах зээлийн харилцаанд шилжих шилжилтийн он жилүүдэд тус аж ахуй нэгж үйл ажиллагаагаа мөн зах зээлийн зарчимд шилжүүлж ажиллах шаардлага зүй ёсоор тавигдаж байжээ.

Гэтэл Залаат УҮГ нь жил ирэх тутам аж ахуй санхүүгийн үйл ажиллагаа нь доголдож санхүүгийн чадавхи нь суларч удирдлага менежмент дутагдахын хэрээр эргэлтийн хөрөнгийн эх үүсвэргүй болж бусад байгууллага аж ахуйн нэгжүүд, иргэдэд төлөх өр төлбөрийн хэмжээ нэмэгдэж 1997 -1999 оны 09 дүгээр сар хүртэл үйл ажиллагаа нь бүрэн зогсож 1996-1998 оны хооронд 3 захирал солигдож өмч хөрөнгө шамшигдаж цагдаа шүүхээр хянагдсан боловч тодорхой үр дүн гарсангүй.

Дүүргийн засаг даргын тамгын газраас тодорхой бодлого явуулж дэмжин үйл ажиллагааг нь 1999 оны 9 сараас хүүхдийн хоолонд батлагдсан эх үүсвэрийг урьдчилан санхүүжүүлэх замаар олгож хангалт нийлүүлэлт хийлгэж эхэлсэн.

2000 оноос “Нөхөрлөл компанийн тухай хууль”-аар Сүхжанжин улсын үйлдвэрийн газар болсон. Өмнөх жилүүдэд үүссэн өр төлбөрийг барагдуулах талаар Засгийн газрын тогтоол гаргаж комисс томилон ажилуулснаас гадна буруутай өр төлбөртэй албан тушаалтнуудын асуудлыг эдийн засгийн цагдаагийн албанд өгч шалгуулах ажлыг хийсэн байна.

Сүхжанжин улсын үйлдвэрийн газар нь Сүхбаатар дүүргийн 23 цэцэрлэгт үйлчилж 4000 гаруй хүүхдэд хүнсний бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлдэг хангамж үйлчилгээг

хариуцахын зэрэгцээ төсвийн байгууллагуудын гал тогооны тоног төхөөрөмжийн хэвийн найдвартай ажиллагааг засвар үйлчилгээ сэлбэг хэрэгсэл, тоног төхөөрөмж, аж ахуйн чанартай бараа бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэх чиг үүрэгтэй байгууллага юм.

Үйл ажиллагаагаа дүүргийн засаг дарга, нийслэлийн өмчийн харилцааны газрын өмнө хариуцан явуулж тайлагнаж дүгнүүлдэг байжээ.

Ингэснээр дээрх компаниудын үйл ажиллагааг өргөтгөх, хариуцлагыг төвлөрүүлэх зорилгоор 2006 оны 06 дугаар сард НИТХТ-чдийн 154 дугаар тогтоолоор дүүрэг бүрийн дэргэдэх “АСГАТ”, “БАЛЧИРХАН”, “ТАХИЛТ”, “ХАН-УУЛ хангамж”, “СҮХ-ЖАНЖИН” УУГ-уудыг татан буулгаж, тэдгээрийн суурин дээр дээрх тогтоолоор “ӨСВӨР-ҮЕ-ХҮНС”, “АСГАТ”, “БАГАЧУУД-ХҮНС” нийслэлийн өмчит үйлдвэрийн газруудыг байгуулсан түүхтэй юм. Ингээд 2006 оны 08 дугаар сараас эхлэн захирлаар нь А.Ариунаа томилогдон ажиллаж ирсэн байна.

2010 оны 06 дугаар сарын 03-ний өдрийн 367 тоот захирамжаар тус өмчит үйлдвэрийн газрын захирлаар Ц.Лхагвасүрэн томилогдон ажиллаж байжээ.

2011 оны 09 дүгээр сард захирал А.Ариунаагийн жирэмсний амралт дуусаж ажилдаа эргэн оржээ.

2013 оны 08 дугаар сарын 23-ний өдрийн Б/90 тоот захирамжаар О.Отгон томилогдон ажиллаж байна.

“БАГАЧУУД ХҮНС” нийслэлийн өмчит үйлдвэрийн газар нь 2006 оноос захирал, ерөнхий нягтлан, тооцооны нягтлан, менежер, эрүүл ахуйч эмч, нярав, үйлчлэгч, жолооч зэрэг 14 ажилтантайгаар Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн 41 цэцэрлэгт хүмүүжиж байгаа 9000 гаруй хүүхэд, багачуудад өдөр тутмын хэрэгцээт хоол хүнсний материал тасралтгүй хүргэж, үйлчлэх үндсэн үүрэгтэйгээр ажлаа хэвийн явуулж байна.

2013 оноос бүтэц орон тооны хувьд Захирал, ерөнхий нягтлан, тооцооны нягтлан, дотоод үйл ажиллагаа хаируцсан мэргэжилтэн, архив бичиг хэрэг, кассын нярав, эрүүл ахуйч эмч, нярав, үйлчлэгч, жолооч зэрэг 16 ажилтантайгаар Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн 49 цэцэрлэгийн 11000 гаруй хүүхэд багачуудыг чанартай баталгаатай, эрүүл ахуйн шаардлага хангасан хүнсний бараа материалаар тасралтгүй хангах үндсэн чиг үүрэгтэй үйл ажиллагаагаа хэвийн явуулж байна.